

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтэс
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;	-	-	-	-	-	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн бодлогын дөрвөн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Энэ хүрээнд “Эдийн засгийн бодлого” болон “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” чиглэлд түлхүү санал боловсруулсан болно. Уг төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хурлын чуулган болон холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэхэд оролцсон бөгөөд 2025 оны 5	100%	100%

							дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдсан болно. Хавсралт: 1 файл		
3.1. 1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Үйл ажиллагааны зардлаар	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	-	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд "Бүсчилсэн хөгжлийн бодлого", "Хүний хөгжлийн бодлого", "Эдийн засгийн бодлого", "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" гэсэн бодлогын дөрвөн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Энэ хүрээнд "Эдийн засгийн бодлого" болон "Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" чиглэлд түлхүү санал боловсруулсан болно. Уг төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, Улсын Их Хурлын чуулган болон холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэхэд оролцсон бөгөөд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдсан болно. Хавсралт: 1 файл	100%	100%
3.2.	Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн	-	-	-	-		Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд буюу дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляц, экспорт, импорт, хөдөлмөр эрхлэлт, төлбөрийн тэнцэл зэрэг үзүүлэлтийн өнөөгийн	100%	100%

22

	засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл хийх;						<p>нөхцөл байдал, богино болон дунд хугацааны тооцоо, төсөөлөл, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын чиглэлүүдийг тодорхойлон Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн баримт бичгүүдэд тусган УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p>Хавсралт: 3 файл</p>		
3.2.1	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай	Үйл ажиллагааны зардлаар	Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол	-	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох дотоодын нийт	100%	100%

	макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.			"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.		танилцуулга/	бүтээгдэхүүн, инфляц, төсвийн үзүүлэлтүүд, хөдөлмөр эрхлэлт, экспорт, импортын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулж, тус баримт бичигт тусгасан. Уг төслийг Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороод болон УИХ-ын чуулганаар хэлэлцүүлсний үр дүнд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн УИХ-ын чуулганаар баталсан. Хавсралт: 1 файл		
3.2.2	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Үйл ажиллагааны зардлаар	Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо	"Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль"-ийн танилцуулга д тооцоо, төсөөллийг хүргүүлсэн.	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026 оны тооцоо, төсөөлөл, тэргүүлэх чиглэлийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын 2026 оны төсвийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляц, төсвийн үзүүлэлтүүд, хөдөлмөр эрхлэлт, экспорт, импортын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2025 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны хүрэх түвшний тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулан тус баримт бичигт тусгасан. Төсвийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хуулийн төслийг	100%	100%

we

							УИХ-ын чуулган, холбогдох байнгын хороодоор хэлэлцүүлэхэд оролцож 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганаар батлагдсан болно. Хавсралт: 1 файл		
3.2.3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Үйл ажиллагааны зардлаар	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	-	2025 онд улирал бүр дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэсэн байна. /4 танилцуулга/	Macro economic diagnostics буюу макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляц, төсвийн үзүүлэлтүүд, хөдөлмөр эрхлэлт, экспорт, импортын 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1 болон 2 дугаар улирлын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зарим үзүүлэлтүүдийн төлөв байдлын талаар нэмэлт судалгаа, шинжилгээ бүхий шигтгээг тусган танилцуулга боловсруулж, яамны удирдлага болон олон нийтэд хүргэх хувилбарыг яамны албан ёсны цахим хуудасны https://med.gov.mn/monthlyreport холбоост болон Macro channel нэртэй вайбэр суваг үүсгэн англи болон монгол хэлээр байршуулж ажиллаж байна. Мөн бусад Улсын Хурлын Их Хурлын гишүүд, яамд, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудад хэвлэн хүргүүлж байна. 2025 оны 3 дугаар	100%	100%

							улирлын тайланг боловсруулж байна. (3 дугаар улирлын гүйцэтгэл 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зарлагддаг болно.) Хавсралт: 3 файл		
3.2.4	Макро эдийн засгийн богино, дунд хугацааны загваруудыг хөгжүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөлд ашиглана.	Үйл ажиллагааны зардлаар	Хөгжүүлсэн загварын тоо	2024 онд 3 загвар хөгжүүлсэн.	-	Загвар хөгжүүлсэн байна. /1 загвар/	- Олон Улсын Валютын Сангаас боловсруулсан САЕМ загварыг шинэчилж, түүний бүтэц, параметрууд болон өгөгдлийн санг сайжруулсан. Монгол Улсын макро эдийн засгийн түүхэн болон сүүлийн үеийн мэдээллийг бүрэн хамруулан, дунд хугацааны гол үзүүлэлтүүдийн төсөөлөл болон тэдгээрийн уялдаа холбоог тооцоолох боломжтой, бүрэн ажиллагаатай загварыг хөгжүүлсэн. Шинэчлэгдсэн САЕМ загварыг макро эдийн засгийн төсөөлөл боловсруулах, бодлогын мэдрэмжийн шинжилгээ хийх, дунд хугацааны төлөвлөлтөд ашиглаж эхлээд байна. - Үйлдвэрлэлийн зөрүү тооцох GAP загварыг уул уурхай тээвэр болон бусад гэсэн хоёр хэсэгт хувааж, үйлдвэрлэлийн зөрүүг дээрх хоёр төрлөөр гаргадаг болгон хөгжүүлсэн. Түүнчлэн, үйлдвэрлэлийн функцийг арга ашиглан үйлдвэрлэлийн	100%	100%

						<p>зөрүүг тооцох тооцооллыг үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын хувь хэмжээг шинж чанараас нь хамааруулан ялгаатай байдлаар тодорхойлж, шинжилгээний арга зүйг хөгжүүлсэн байна. - PEP-1 загварын өргөтгөсөн хувилбарыг ашиглан Уран олборлох төслийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсон. Тооцооллыг 2018 оны нийгмийн тооцооллын матриц (Social Accounting Matrix, SAM) дээр суурилан, динамик CGE загвар ашиглан гүйцэтгэсэн бөгөөд төсөл нь салбарын үйлдвэрлэл, экспорт, ажлын байр, орлогын түвшинд үзүүлэх нөлөөллийг тооцоолсон. Үр дүнд нь Уран олборлолт нь дунд хугацаанд дотоодын нийт бүтээгдэхүүнд эерэг нөлөө үзүүлж, ажлын байр болон экспортын орлого нэмэгдэх боломжтойг тогтоосон. - PEP-1-1 стандартын статик CGE загвар (нэг улс, олон салбар, олон бүтээгдэхүүнтэй) ашиглан цахилгааны үнийн өсөлт Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсон. Тооцооллын үр дүнд цахилгааны үнийн өсөлт нь хэрэглээ, үйлдвэрлэл,</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

27

							инфляцад тодорхой сөрөг нөлөө үзүүлж, зарим салбарын үр ашиг буурах магадлалтайг илэрхийлсэн. Хавсралт: 1 файл		
3.3.	Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох;	-	-	-	-		Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад болон дотоод эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх боломжит нөлөө, сувгийг үнэлсэн дүн шинжилгээ бүхий тайлан боловсруулсан. Тус тайланд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал, санхүүгийн зах зээлийн нөхцөл, дотоодын эрэлт, төсвийн гүйцэтгэл, инфляцын эрсдэл зэрэг гол хүчин зүйлсийг хамруулсан. Боловсруулсан эрсдэлийн үнэлгээний тайланг дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, мөн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн макро эдийн засгийн танилцуулгыг боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигласан. Хавсралт: 1 файл	100%	100%
3.3.	Монгол Улсын	Үйл	Танилцуулга	2024 онд	-	Болзошгүй	Монгол Улсын эдийн засагт	100%	100

1	эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана.	ажиллагааны зардлаар	д туссан тоо	батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдож болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан.		эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /2 танилцуулга/	тохиолдож болзошгүй гадаад болон дотоод эрсдэлийг тодорхойлж, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх боломжит нөлөө, сувгийг үнэлсэн дүн шинжилгээ бүхий тайлан боловсруулсан. Тус тайланд түүхий эдийн үнийн хэлбэлзэл, гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал, санхүүгийн зах зээлийн нөхцөл, дотоодын эрэлт, төсвийн гүйцэтгэл, инфляцын эрсдэл зэрэг гол хүчин зүйлсийг хамруулсан. Боловсруулсан эрсдэлийн үнэлгээний тайланг дунд хугацааны бодлогын баримт бичиг болох Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, мөн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн макро эдийн засгийн танилцуулгыг боловсруулахад суурь мэдээлэл болгон ашигласан. Хавсралт: 1 файл		%
3.3.2	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн,	Үйл ажиллагааны зардлаар	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	-	Сар бүр танилцуулга бэлтгэсэн байна. /12 танилцуулга/	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляц, төсвийн үзүүлэлтүүд, гадаад валютын нөөц, экспорт, импорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн хүү, хөдөлмөр эрхлэлт,	100%	100%

	удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.						дундаж цалин, өрх болон аж ахуйн нэгжийн статистик, гадаад худалдааны түнш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлын талаархи мэдээллийг 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 10 дугаар сар хүртэлх гүйцэтгэлээр нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, олон нийтэд хүргэх хувилбарыг яамны албан ёсны цахим хуудасны https://med.gov.mn/monthlyreport холбоост болон Macro channel нэртэй вайбэр суваг үүсгэн англи болон монгол хэлээр байршуулж ажиллаж байна. Мөн дотоодын байгууллагуудаас тоо, мэдээлэл нэмэлтээр авч яамны удирдлагуудад зориулсан дэлгэрэнгүй хувилбарыг А5 хэмжээтэй товхимол болгон хэвлэж гаргадаг бөгөөд мөн адил англи, монгол хувилбараар бэлтгэж байна. 2025 оны 11 дүгээр сарын танилцуулгыг боловсруулж байна. (11 дүгээр сарын гүйцэтгэл 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зарлагддаг болно.) Хавсралт: 11 файл		
3.3.3	Өдөр тутмын шуурхай мэдээлэл бэлтгэх,	Үйл ажиллагааны зардлаар	Мэдээллийн тоо	Түүхэн мэдээллийн сан үүсгэсэн	-	Тухай бүр мэдээллээр хангасан	Гадаад худалдааны голлох тоо мэдээлэл болох экспорт, импортын өдөр тутмын	100%	90%

	<p>голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн мэдээллийн сан үүсгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангана.</p>					<p>байна. /тухай бүр/</p>	<p>мэдээлэл, хилээр орсон болон гарсан машин, дэлхийн зах зээл дээрх голлох түүхий эдийн үнэ, гадаад валютын ханшийн мэдээллийг өдөр бүр нэгдсэн системд оруулж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Нийт экспорт болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын долоо хоногийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж ажилласан. Мөн уул уурхайн биржийн өмнөх өдрийн арилжаа, дэлхийн зах зээлийн үнийн мэдээлэл, болон зарим голлох бүтээгдэхүүний экспорт, импортын тоонд дүн шинжилгээ хийж, өдөр бүрийн хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан.</p>		
3.4.	<p>Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;</p>	-	-	-	-		<p>Судалгааг хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах нь тухайн судалгааны үр дүнгийн нарийвчлал, бодлогын шийдвэрт нөлөөлөх ач холбогдлыг нэмэгдүүлэхэд чухал юм. Энэ хүрээнд НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.</p>	100%	90%

					<p>Гааль, И-баримтын датаг сар бүр тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирлын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Түүнчлэн өрхийн худалдан авах чадварын индекс боловсруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 4 дэлгүүрийн 6 барааны худалдан авалтын дүнг И-баримтын тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлж, туршилт тооцоог боловсруулаад байна. Ингэхдээ И-баримтын микро тоон мэдээллийг ашиглан өрхүүдийн худалдан авалтын бүтээгдэхүүний бүтцийг судлахад, тоон мэдээлэл нь задгай буюу ангилагдаагүй барааг машин сургалтын аргын тусламжтайгаар ангилж, төрөлжүүлсэн. Үүний дараа өрхүүдийн заавал хэрэглэх шаардлагатай суурь хэрэглээг тодорхойлж, мөн заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч тусгай зориулалтаар хэрэглэх барааг тодорхойлсон. Үүний үр дүнд өрхүүдийн бараа</p>		
--	--	--	--	--	--	--	--

30

							бүтээгдэхүүний хэрэглээний чиг хандлага, хэрэглээний түвшин, авокадо индекс зэрэг микро эдийн засгийн ач холбогдол бүхий нарийвчилсан дүн шинжилгээг боловсруулж, үр дүнг илүү ач холбогдолтой болгох үүднээс дашбоард болгон автоматжуулсан.		
3.4.1	Дата баазууд боловсруулж эдийн засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)	Үйл ажиллагааны зардлаар	Тайланд ашигласан тоо	-	-	Улирлын тайланд ашигласан байна. /3 удаа/	НӨАТ-ын дата баазад суурилж аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын сар, улирлын давтамжтай дата, мэдээллээр мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Гааль, И-баримтын датаг сар бүр тогтмол авч аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого, НӨАТ-ын шивсэн баримтын тоонд тооцоо, судалгаа хийж макро эдийн засгийн улирлын танилцуулгад оруулж, удирдлагыг холбогдох мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Түүнчлэн өрхийн худалдан авах чадварын индекс боловсруулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран 4 дэлгүүрийн 6 барааны худалдан авалтын дүнг И-баримтын тоон мэдээлэлд үндэслэн тодорхойлж, туршилт тооцоог боловсруулаад байна.	100%	100%

							<p>Ингэхдээ И-баримтын микро тоон мэдээллийг ашиглан өрхүүдийн худалдан авалтын бүтээгдэхүүний бүтцийг судлахад, тоон мэдээлэл нь задгай буюу ангилагдаагүй барааг машин сургалтын аргын тусламжтайгаар ангилж, төрөлжүүлсэн. Үүний дараа өрхүүдийн заавал хэрэглэх шаардлагатай суурь хэрэглээг тодорхойлж, мөн заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч тусгай зориулалтаар хэрэглэх барааг тодорхойлсон. Үүний үр дүнд өрхүүдийн бараа бүтээгдэхүүний хэрэглээний чиг хандлага, хэрэглээний түвшин, авокадо индекс зэрэг микро эдийн засгийн ач холбогдол бүхий нарийвчилсан дүн шинжилгээг боловсруулж, үр дүнг илүү ач холбогдолтой болгох үүднээс дашбоард болгон автоматжуулсан.</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
3.4.2	Монгол Улсын төсвийн дунд хугацааны эрсдэлийг тодорхойлж танилцуулга бэлтгэн богино, дунд хугацааны бодлогын баримт	Үйл ажиллагааны зардлаар	Танилцуулгын тоо	-	-	Танилцуулга боловсруулсан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны	100%	90%

	бичигт тусгана.						төсвийн төсөөллийн тухай хууль, мөн нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар батлуулах хүрээнд макро эдийн засагт тулгарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн дэлгэрэнгүй танилцуулгад тусган боловсруулсан. Үүнд худалдааны дайн, хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний тасалдал, зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг зэрэг макро эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлсон болно.		
3.5.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;	-	-	-	-	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг болосвруулж макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, ажил эрхлэлт ажилгүйдлийн түвшин, нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд, гадаад	100%	100%	

						худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл зэрэг үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026-2028 оны төсөөллийн тооцоог боловсруулан танилцуулгад тусгасан. Тус хууль 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Мөн 2025 оны I улиралд нүүрсний олон улсын зах зээл дэх үнэ буурч, улмаар төсвийн орлого тасалдсанаар тус хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эцэслэн батлуулсан болно. Хавсралт: 3 файл			
3.5.2	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын	Үйл ажиллагааны зардлаар	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	-	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026-2028 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулсан байна. /1 танилцуулга/	"Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг боловсруулж макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болох дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, ажил эрхлэлт ажилгүйдлийн түвшин, нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд, гадаад худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл зэрэг	100%	100%

<p>хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>						<p>үзүүлэлтүүдийн 2023 оны гүйцэтгэл, 2024 оны урьдчилсан гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026-2028 оны төсөөллийн тооцоог боловсруулан танилцуулгад тусгасан. Тус хууль 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Мөн 2025 оны I улиралд нүүрсний олон улсын зах зээл дэх үнэ буурч, улмаар төсвийн орлого тасалдсанаар тус хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр эцэслэн батлуулсан болно.</p> <p>Хавсралт: 2 файл</p>		
---	--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

И.Батхүү

И.Батхүү
(гарын үсэг)

2025.12.15
(огноо)



Тайлагнасан:

Ц.Мөнхдэлгэр

Эдийн засгийн бодлого,
төсөөллийн хэлтсийн дарга
(албан тушаал)

Ц.Мөнхдэлгэр
(гарын үсэг)



2025.12.15

(огноо)